



**МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 417

Ховд

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Зөөлөн тэмүүлэл констракшн” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Цэцэрлэгийн барилгын дээвэр засвар /Мөст сум/-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

- Ажлын хэсгийн ахлагч: Б.Даваадорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Гишүүд: Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Ц.Цолмонбаатар - Стандарт, хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн
- Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
- Л.Бямба-Очир - Мөст сумын Засаг даргын Тамгын газрын дарга
- П.Баянзул - Мөст сумын Цэцэрлэгийн нягтлан бодогч
- С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга
- У.Болдбаяр - “Зөөлөн тэмүүлэл констракшн” ХХК-ийн захирал

-2-

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын мэргэжилтэн

2. "Зөөлөн тэмүүлэл констракшн" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Даваадорж)-д даалгасугай.

3. Дээрх ажилтай холбогдолтой гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Дөлбадрал)-д даалгасугай.

